



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/145

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 сарын 24-ний өдрийн 2/06 тоот тогтоол, аймгийн Онцгой комиссын 28 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ковид-19 цар тахалтай холбогдуулан бэлтгэсэн нөөцийн махны хадгалалтыг хариуцан гүйцэтгэгч “Хан жаргалант Ховд” хоршоонд хадгалалтын зардал болох 10 780 000 төгрөг/арван сая долоон зуун наян мянган/-ийг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 10 780 000 төгрөг/арван сая долоон зуун наян мянган/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2/06 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан аймгийн төсвийн 2020 оны санхүүжилтээс барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн орлогоос олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ